

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### **Автобензиний ерөнхий шаардлага:**

Монгол улсын MNS 0217:2017 стандартын шаардлагыг хангасан байна.

#### **Зориулалт, хэрэглээ:**

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй "Бор-Өндөр" уулын баяжуулах үйлдвэр (УБҮ)-ийн, мөн Төв аймгийн Заамар суманд үйл ажиллагаа явуулж буй "Шижир алт" алтны үйлдвэрийн тусгай болон ачааны, хүн тээврийн зориулалтын тээврийн хэрэгслүүдийг ажиллуулахад зориулна.

#### **Автобензиний физик-химийн болон ашиглалтын үзүүлэлт**

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт
		АИ-92
1	Октаны тоо (шинжилгээний аргаар), багагүй	92
2	Экологийн ангилал, багагүй	K2
3	Хар тугалганы агууламж, мг/дм <sup>3</sup> , ихгүй	5
4	Уусгагчид угаагдах давирхайн хэмжээ, мг/дм <sup>3</sup> , ихгүй	50
5	Исэлдэлтийн тогтвор, мин, багагүй	360
6	Хүхрийн агууламж, мг/кг, ихгүй	500
7	Бензолын агууламж, эзлэхүүний хувь %, ихгүй	5
8	Усны агууламж, мг/кг, ихгүй	200
9	Нийт бохирдол, мг/кг, ихгүй	24
10	Зэс хавтгайн туршилт (50°C-т 3 цаг)	Ангилал 1
11	Нягт, 15°C-т, кг/м <sup>3</sup>	725.0-780.0
12	Өнгө, гадна төрх	Цэвэр, тунгалаг
13	Төлөв	Шингэн

#### **Нэмэлт шаардлага:**

1	Бензин нь металл (маргенец, хар тугалга, төмөр зэрэг)-тай чанар сайжруулагч нэмэлт агуулаагүй байна.
2	Нийлүүлэгч /импортлогч, борлуулагч мөн адил/ нь бензинд октаны тоо нэмэгдүүлэгч болон бусад чанар сайжруулагч нэмэлт нэмж, хольж болохгүй.
3	Нийлүүлэхээр санал болгож буй бензинийг техникийн шаардлагад нийцэх эсэхийг тодорхойлох зорилгоор үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ, магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.
4	Нийлүүлэх бензин 2024 оны 1 дүгээр сараас хойш үйлдвэрлэгдсэн байна.
5	Нийлүүлэгч нь Улаанбаатар хот болон хот хоорондын улсын чанартай төв зам дагуу өөрийн эзэмшлийн шатахуун түгээх станцуудтай байна.